

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2022.12.07

Аймгийн Засаг даргын Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийж, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажилласан.



НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ, ДҮГНЭЛТ

Хууль зүйн салбарт 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр аймгийн Хууль эрх зүйн хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хууль зүйн салбарт 2022 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээг 1 дүгээр хавсралтаар 19 арга хэмжээ, Засаг даргын хүлээх үүргийг гэрээний 3 дахь хэсэгт 23 үүрэг, нийт 42 арга хэмжээ тусгасан байна. Эхний хагас жилийн хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээ хийхэд 85.5 хувьтай байсан ба явцын хяналт шинжилгээгээр хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх талаар чиглэл арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаар жилийн эцсийн байдлаар 90.8 хувьтай хэрэгжүүлсэн байна.

ХОЁР. ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, аймгийн Засаг даргын шийдвэрээр 2022 оныг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан шинээр батлагдан хэрэгжиж буй хууль тогтоомжуудаар иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдын эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилт тавин тус хугацаанд цахимаар болон танхимын хэлбэрээр аймаг, сумын Эрх зүйн хөтчүүд нийтдээ эрх зүйн сургалтыг 131 удаа, 7545 хүнд буюу 16-аас дээш насны иргэдийн 23.5 хувьд эрх зүйн сургалт зохион байгуулж, хууль зүйн тусламж үйлчилгээг 300






хүнд үзүүллээ.

"Хүний хөгжлийг дэмжих жил"-д зориулан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд сумдад бэлтгэгдсэн 60 "Эрх зүйн хөтөч"-ийг давтан сургаж чадавжуулах ажлыг зохион байгууллаа.




Аймгийн ГХУСАЗСЗ-тэй хамтран сумдын Эрх зүйн хөтөч болон ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын дунд тэдний үйл ажиллагааг тогтмолжуулах, иргэд, олон нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх, багаар ажиллуулах зорилготой болзолт уралдаан зарлан, иргэд, малчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр "Хууль тогтоомж сурталчлах", "Малчдын зөвлөгөө", "Малчны нэг өдөр" өдөрлөг, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сум бүрд" зэрэг арга хэмжээнүүдийг Дэлгэрцогт, Өлзийт, Дэрэн, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Өндөршил, Баянжаргалан, Хулд, Луус сумдын 788 иргэд, олон нийтийг оролцуулсан нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.



Аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэг 11 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 21.4 хувиар буурсан ба хэргийн илрүүлэлт 36.4 хувьтай байгаа нь "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сум бүрд" зохион байгуулсны үр дүр юм.

Зам тээврийн гэмт хэрэг, ослын нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр "Согтуугаар тээврийн хэрэгсэл бүү жолоод", "Та бага насны хүүхдийг зориулалтын суудалд суулгаж аюулгүй зорчих", "Хамгаалах бүсээ бүслэх гурван секунд таны ирээдүйн амьдралын баталгаа", "Жолооны ард утсаар бүү оролд бүү ярь", "Таны



хурд хэтрүүлсэн хором мөч бүхэн хэн нэгний амьдралыг орвонгоор нь өөрчлөхөд бэлэн байдаг” гэх зэрэг 5 төрлийн 150 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нарт тарааж ажилласан.



Төрийн архивд зориулалтын 16 ширхэг нягтруулсан шүүгээ, хадгаламжийн 2 санд хяналтын камер, агааржуулалтын систем, хурдны скайнер, тусгай зориулалтын баримт хадгалахад зориулж 2 ширхэг шүүгээ зэргээр ханган, баримт бичгийн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулахад нийт 19.0 сая төгрөгийг зарцуулсан.



Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах ажлын хүрээнд Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 440 иргэн хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг үзүүлж 3800 хуудас хувийн хэргийг цахимжуулан мэдээллийн санд оруулсан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2811 бүртгэл бүртгэж, улсын бүртгэлийн нийт 8000 бүртгэлийн 32247 хуудас архивын баримтын шаардлага хангасан эх нотлох баримт, нийт 4749 бүртгэлийн 10217 хуудас баримтыг цахимжуулсны үр дүнд баримтыг ашиглах, засварлах программын хэрэглээ сайжирч цаг хугацааг хэмнэж мэдээллийг түргэн шуурхай солилцох, дамжуулах нөхцөл боломжийг бүрэн бүрдүүлсэн байна.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас хууль хяналтын байгууллагын алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор энгэрийн камер 7, хэт богино долгионы радио холбоо 6, мөн богино долгионы радио холбооны нөөц тэжээл 20 ширхэг зэрэг 12.700.000 төгрөгийн тоног төхөөрөмж, Цагдаагийн газрын насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөний засвар, тохижилтын ажилд 5.0 сая төгрөгийн дэмжлэг, Эрүүлжүүлэх баривчлах байрны агааржуулах төхөөрөмжийн 2.3 сая төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тус тус шийдвэрлүүлсэн.



Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд хууль, хяналтын байгууллагуудын алба хаагчдын орон байрны дэмжлэгт зориулан Цагдаагийн газрын цагдаа жолооч Д.Чимэддоржид 7.0 сая төгрөг, Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Ш.Чулуун, Ё.Батбаяр нарт тус бүр 10.0 сая төгрөгийг нийт 27.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

ГУРАВ. ДУТАГДАЛТАЙ ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Тухайн жилд бүртгэгдсэн 220 гэмт хэрэгт 176 хүн холбогдсон ба эдгээрийн 10.8 хувь нь эмэгтэй хүн байна. Мөн гэмт хэрэгт холбогдогчдын 70.5 хувийг эрхэлсэн тодорхой ажилгүй болон малчин иргэд байна. Хүнийг санаатай алах гэмт хэрэг 4 нэгжээр буюу 2.3 дахин, хүчиндэх гэмт хэрэг 3 буюу 42.8 хувь, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4 буюу 4.82 хувь, хулгайлах гэмт хэрэг 4 буюу 9.3 хувь, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 7 буюу 9.21 хувь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 6 буюу 46.1 хувь, залилах гэмт хэрэг 2 буюу 6.25 хувь тус тус урд оны мөн үеэс өссөн. Статистик үзүүлэлтээс харахад эрэгтэйчүүдийн гэмт хэрэгт илүү өртдөг шалтгаан нь эрхэлсэн тодорхой ажилгүй, боловсролын түвшин бага, архи согтууруулах ундааны хэрэглээ өндөр, хууль эрх зүйн мэдлэг хангалтгүй зэргээс шалтгаалж байна. Дээрх гэмт хэргийн тоо өссөн нь өнгөрөгч 2021 онд Ковид-19 цар тахлын улмаас удаан хугацаанд хорио тогтоосонтой холбоотой гэмт хэргийн гаралт өмнөх жилүүдээс харьцангуй буурсан байсантай холбоотой байна.

“Түр хамгаалах байр”-ыг байгуулах зураг төсвийг гарган хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох газруудад хүсэлт хүргүүлсэн боловч Төрийн хэмнэлтийн хуультай холбогдуулан хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн

12 сарын 05-ны өдрийн хурлаар Цагдаагийн газрын ашиглаж байсан хуучин барилгыг засварлаж, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах”, “Иргэдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллээр үйлчлэх төв”-ийн зориулалтаар ашиглахаар Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраар зураг төсвийг гаргуулж, 2023 оны орон нутгийн төсөвт 250.0 сая төгрөгийг батлууллаа.

ДӨРӨВ. САНАЛ, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний Хууль зүйн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 90,8 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 3б хавсралтын дагуу оны эхэнд боловсруулан саналаа хүргүүлэхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагыг ханган томъёолж, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон, суурь түвшин, хүрэх түвшинг бодитой тооцон төлөвлөж батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх шаардлагатай байна.

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга

Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын

албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн ахлах мэргэжилтэн

Э.Одончимэг